



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багабаян энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/101/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Лхагвацэнд Утас: 261805 Цахим хаяг: khagvatsendb@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэгмиддорж Утас: 263533 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 93099119 Цахим хаяг: info@ghtaudit.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/741

танай _____-ны № _____-т

БАГАБАЯН ЭНХИЙН ТӨЛӨӨ
ЦОГЦОЛБОР ТӨВ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.ГАНБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу, жилийн эцэст өр төлбөр, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсантай холбогдуулан усан бассейныг засварлаж, зориулалтын дагуу ашиглаж хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, кассын үйл ажиллагааны журмыг баримталж ажилладаггүй зэрэг 26.5 сая төгрөгийн залруулаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон 14.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14, 18, 20 дугаар зүйл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 28 дугаар зүйлтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын эзэмшлийн газрыг Сүхбаатар дүүргийн газрын албанаас иргэн аж ахуйн нэгжид давхардуулан олгосон байгаад шүүхийн маргаан үүсгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын мал амьтдаас 16.6 сая төгрөгийн өртөг бүхий мал хорогдсоныг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн данс бүртгэлээс хасжээ.

Бусад асуудлын хэсэг

Ковидын жилүүдэд бассейны усыг шавхаж, үйл ажиллагаа хэвийн явагдах үед дахин дүүргэлт хийх боломжгүй болсныг холбогдох мэргэжлийн байгууллагаас стандартад нийцээгүй гэсэн дүгнэлт гаргажээ.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	219,552,857.68	13,813,632.20
1.1.2	Дансны авлага	99,749,066.95	162,783,898.14
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага	1,050,000.00	
1.1.6	Бараа материал	364,913,774.76	384,568,807.37
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	111,421,997.33	108,560,439.13
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	102,230,000.00	100,290,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	898,917,696.72	770,016,776.84
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,289,217,692.24	3,065,842,499.18
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,289,217,692.24	3,065,842,499.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,188,135,388.96	3,835,859,276.02
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	7,104,183.73	58,019,309.65
2.1.1.3	Татварын өр	15,718,234.34	19,206,089.27
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	162,104,580.08	74,420,790.08
2.1.1.9	Нөөц/ өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	184,926,998.15	151,646,189.00
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн	184,926,998.15	151,646,189.00
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	943,008,420.00	943,008,420.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,095,895,116.30	2,079,812,171.30
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	580,892,169.99	580,892,169.99
2.3.9	Хуримтлагдсан ашиг	383,412,684.52	80,500,325.73
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,003,208,390.81	3,684,213,087.02
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,188,135,388.96	3,835,859,276.02

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,358,479,284.54	1,273,805,101.64
2	Борлуулалтын өртөг	444,622,009.71	904,569,316.94
3	Нийт ашиг (алдагдал)	913,857,274.83	369,235,784.70
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		903,449.07
6	Бусад орлого	96,304,990.33	327,583,083.01
7	Борлуулалт маркетингийн зардал	456,521,340.76	65,628,246.80
8	Ерөнхий ба удирдлагын зардал	500,013,562.58	811,168,314.73
9	Санхүүгийн зардал		
10	Бусад зардал	21,656,434.00	26,727,796.12
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	20,011.17	(7,732.43)
12	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		(99,840,588.28)
13	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	31,990,938.99	(305,650,361.58)
14	Орлогын татварын зардал	3,199,080.39	90,344.90
15	Татварын дараах ашиг (алдагдал)	28,791,858.60	(305,740,706.48)
16	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	28,791,858.60	(305,740,706.48)
17	Бусад дэлгэрэнгүй орлого	(69,393,227.94)	(3,300,000.00)
18	Бусад олз, гарз	(69,393,227.94)	(3,300,000.00)
19	Орлогын нийт дүн	(40,601,369.34)	(309,040,706.48)
20	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0	0

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.30	580,892,169.99	424,014,053.86	4,043,809,760.15
2	Өмчид гарсан өөрчлөлт				(69,393,227.94)	-69,393,227.94
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				28,791,858.60	28,791,858.60
4	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.30	580,892,169.99	383,412,684.52	4,003,208,390.81
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				14,765,905.27	
6	Залруулсан үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.30	580,892,169.99	398,178,589.79	4,017,974,296.08
7	Бусад дэлгэрэнгүй орлого				(3,300,000.00)	(3,300,000.00)
8	Өмчид гарсан өөрчлөлт		(16,082,945.00)			(16,082,945.00)
9	Зарласан гнгдол ашиг				(8,637,557.58)	(8,637,557.58)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(305,740,706.48)	(305,740,706.48)
11	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,079,812,171.30	580,892,169.99	80,500,325.73	3,684,213,087.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,918,356,094.42	1,515,342,337.75
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,858,049,780.07	1,435,673,047.40
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		46,219.00
	Буцаан авсан албан татвар	49,095,492.69	2,112,575.00
	Татаас, санхүүжилтийн орлого		68,377,550.00
	Бусад мөнгөн орлого	11,210,821.66	9,132,946.35
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,842,818,419.87	1,712,436,273.22
	Ажиллагчдад төлсөн	322,147,087.00	553,095,369.73
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	125,135,501.04	140,085,714.44
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,110,883,408.58	701,042,711.37
	Ашиглалтын зардалд төлсөн	63,104,564.12	136,767,629.08
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	788,500.00	1,685,000.00
	Татварын байгууллагад төлсөн	162,792,697.91	94,164,960.35
	Даатгалын төлбөр төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	57,966,661.22	85,594,888.25
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	75,537,674.55	(197,093,935.47)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,751,451.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	33,751,451.00	
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(33,751,451.00)	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,530,169.47
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	2,530,169.47
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	11,175,459.48
	Төлсөн ногдол ашиг		8,637,557.58
	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		2,537,901.90
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(8,645,290.01)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	41,786,223.55	(205,739,225.48)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,766,634.13	219,552,857.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	219,552,857.68	13,813,632.20

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2022 он гүйцэтгэл	2023 оны		Өсөлт +/-, бууралт +/-	
		Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	1,454,874,274.87	1,732,000,000	1,409,996,925.19	322,003,074.81	81.4
Нийт зардал	1,422,833,358.22	1,646,410,000	1,715,737,631.67	(69,327,631.67)	104.2
Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	444,622,009.71	432,926,000	904,569,316.94	(471,643,316.94)	208.9
б) Удирдлагын зардал	500,013,562.58	1,213,484,000	811,168,314.73	402,315,685.27	66.8
Үндсэн болон нэмэгдэл цалин	263,884,235.63	650,080,000	339,674,815.36	310,405,184.64	52.3
Нийгмийн даатгалын шимтгэл	30,261,702.00	81,260,000	14,653,638.22	66,606,361.78	18.0
Түлш шатахуун	14,968,296.13	30,828,000	25,458,074.10	5,369,925.90	82.6
Ашиглалтын зардал	20,314,192.46	94,640,000	63,117,075.29	31,522,924.71	66.7
Засвар үйлчилгээ	746,363.64	45,000,000	15,456,214.28	29,543,785.72	34.3
Шуудан холбоо	2,227,790.08	1,800,000	26,072,290.12	(24,272,290.12)	1,448.5
Бичиг хэргийн зардал	4,164,599.02	4,500,000	3,679,894.99	820,105.01	81.8
Тээврийн хэрэгслийн татвар	620,000.00			-	
Үндсэн хөрөнгийн элэгдэл	90,973,820.99	235,380,000	147,196,659.74	88,183,340.26	62.5
Түрээсийн зардал	1,400,000.00	-	900,000.00	(900,000.00)	
Мэргэжлийн үйлчилгээ	6,105,481.82	-	11,492,600.02	(11,492,600.02)	
Томилолт	100,000.00	-	9,333,660.00	(9,333,660.00)	
Бусад зардал	64,247,080.81	69,996,000	154,133,392.61	(84,137,392.61)	220.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	31,990,938.99	85,590,000	(305,740,706.48)	391,330,706.48	(357.2)
Цэвэр ашиг/алдагдал	28,791,858.60	77,031,000	305,740,706.48	(228,709,706.48)	396.9
Төрийн өмчид төвлөрүүлэх ашиг	8,637,557.58	23,109,300	-	23,109,300.00	-
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.91			-	
Нийт ажиллагсдын тоо	53	58	55	3	94.8
Нийт цалингийн сан	559,082,906.63	650,080,000	673,589,568.00	(23,509,568.00)	103.6

3. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 100.8 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө актлахдаа тухайн хөрөнгийн 16.1 сая төгрөгийн дахин үнэлгээг буруулж бүртгээгүй.
2. Санхүүжилтийн 33.4 сая төгрөгийн орлогыг буруу бүртгэснээр өр төлбөрийг өсгөсөн.
3. Малын 16.6 сая төгрөгийн хорогдлыг мал эмнэлэгийн байгууллагаар баталгаажуулан бүртгэлээс хассаныг холбогдох данс бүртгэлээр дамжуулан бүртгээгүй.
4. Харилцагч банкны 0.4 сая төгрөгийн үүний орлогыг бусад орлогоор бүртгэсэн
5. Тайлант онд 33.3 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийн тооцоолол алдаатай хийгдсэн алдааг тус тус залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдүү		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгө актлахдаа тухайн хөрөнгийн дахин үнэлгээг буруулж бүртгээгүй	1	16,082.9			1	16,082.9	1	16,082.9				
Санхүүжилтийн орлогыг буруу бүртгэснээр өр төлбөрийг өсгөсөн	1	33,377.5			1	33,377.5	1	33,377.5				
Малын хорогдлыг мал эмнэлэгийн байгууллагаар баталгаажуулан бүртгэлээс хассаныг холбогдох данс бүртгэлээр дамжуулан бүртгээгүй байна.	1	16,615.0			1	16,615.0	1	16,615.0				
Хүүний орлогыг бусад орлогоор бүртгэсэн	1	361.0			1	361.0	1	361.0				
ББӨ-ийн тооцоолол алдаатай хийгдсэн	1	34,337.3			1	34,337.3	1	34,337.3				
					0	-	0	-				
Дүн	5	100,773.8			5	100,773.8	5	100,773.8				

Аудитаар нийт 26.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 14.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 12.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсантай холбогдуулан усан бассейныг засварлаж, зориулалтын дагуу ашиглаж хөрөнгийн үр ашгийг ээшлүүлэх	1	0					1	-				
оны жилийн эцэст 5 харилцагч байгууллагын 14.3 сая төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна.	1	14,303.1			1	14,303.1						
НББББ-ийн дагуу кассын үйл ажиллагааны журмыг бариталж ажилладаггүй	1	0					1	-				
Зарим гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл дутуу	1	12,185.9					1	12,185.9				
Дүн	4	26,489.0			1	14,303.1	3	12,185.9				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.